
Төв аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын орлогын ногдуулалтанд үндэслэдэггүй өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөж байна

Аймгийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэл, биелэлтийн байдал



2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Асуудал 1 <i>СТСХэлтэс нь татварын орлогын суурь судалгаа мэдээлэл хангалтгүй, бааз суурийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.5-11</i>
Аудитын менежер О.Амаржаргал	Асуудал 2 <i>Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын оны эхний дутуу төлөлт 49.8 хувийн барагдалттай байгаа нь татварын дутуу төлөлтийн шалгуур үзүүлэлтэнд хүрч ажиллаагүй байна.....12-14</i>
Ахлах аудитор Т.Майцэцэг Ц.Базарсад Ц.Саранчимэг Аудитор Ж.Бямбацогт О.Сосор Шинжээч Ц.Хишигжаргал Ч.Батэрдэнэ А.Батлхагва	Асуудал 3 <i>Аймаг, сумдын санхүүгийн тайланд тусгагдсан татварын орлого нь татварын хэлтсийн орлогын мэдээнээс зөрүүтэй байх зөрчил байсаар байна.....15-16</i>
	Дүгнэлт 17
	Зөвлөмж 18
	Холбогдох байгууллагын санал:
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 19
2016 оны 11 дугаар сарын 21-ны өдөр	Саналд өгсөн тайлбар
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70272463 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТТХ	Авто тээвэх болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ТГӨО	Төсөвт газрын өөрийн орлого
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ББАТ	Байгалийн баялаг ашигласны төлбөр
ОНТ	Орон нутгийн төсөв
ОНХ	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
МУЗГ	Монгол улсын засгийн газар

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг аймгийн ИТХурлын захиалгаар 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаныг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Төв аймгийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөгөөний үндэслэл, биелэлтийн байдал холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.Үүнд:

- Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөө бодитой хийгдсэн эсэх
- Аймгийн төсвийн орлого, эх үүсвэрийн бүрдүүлэлтийг жигд хангасан эсэх
- Аймгийн төсвийн орлогыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх

Аудитад СТСХэлтэс, Татварын хэлтэс, ГХБХБГазар, УБХэлтэс, Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Архуст, Баянжаргалан, Бүрэн, Баян-Өнжүүл, Лүн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Өндөрширээт, Аргалант зэрэг сумдын аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын ногдуулалт, төлөвлөлт, гүйцэтгэлийн суурь судалгаа мэдээлэл, 2016 оны эхний 10 сарын байдлаарх татварын орлогын болон өрийн барагдуулалтын мэдээ тайлан болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, АДБОУС 4100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- НББ-ийн тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Усны төлбөрийн тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- АТБӨЯХэрэгслийн албан татварын тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандартууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Базарсад, Ц.Саранчимэг аудитор Ж.Бямбацогт, О.Сосор, шинжээч Ц.Хишигжаргал, Ч.Бат-Эрдэнэ, А.Батлхагва нар 2016 оны 9-р сарын 19-нээс 11-р сарын 21-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

СТСХэлтэс нь татварын орлогын суурь судалгаа мэдээлэл хангалтгүй, бааз суурийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

1.1 СТСХэлтэс нь татварын орлогын суурь судалгаа мэдээлэл хангалтгүй, бааз суурийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн төсвийн орлогын ногдуулалт, төлөвлөлтийн үндэслэлд дүгнэлт өгөхийн тулд гол нэр төрлийн татварын орлогын суурь судалгааг авч үзэх шаардлага гардаг. Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс нь аймгийн орлого бүрдүүлэлтэд гол үүрэгтэй оролцдог хэлтсийн хувьд татварын орлогыг бүрдүүлэх бааз суурийг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй, илүү, дутуу төлөлтийг баталгаажуулаагүй, хяналт тавьдаггүй зөвхөн Татварын хэлтсийн мэдээнээс өөр суурь судалгаа мэдээлэлгүй байна. Жишээлбэл аймгийн төсвийн гол нэр төрлийн орлого болох газрын төлбөр, АТБӨЯХАТ, ҮХЭХАТ, ус ашигласны төлбөр зэрэг татварын орлогын дутуу төлөлтийн судалгаа тус хэлтэсийн орлогын мэргэжилтэнд байхгүй байна.

Аудитаар аймгийн Татварын хэлтсээс үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулалтын судалгааг гаргуулан авахад 929 татвар төлөгчөөс 331.5 сая төгрөгийн татвар ногдуулсан судалгаа ирүүлсэн. Гэтэл үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой судалгааг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргуулж үзэхэд 1588 татвар төлөгч, 752.2 сая төгрөгийн татвар ногдох үл хөдлөх хөрөнгө байна. Эндээс үзэхэд хэлтэс, агентлагуудын ажлын уялдаа байхгүй, эдгээрийг холбон зангидах, бодлого гаргаж хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Аймгийн хэмжээний ус ашиглагчдын суурь судалгаа байхгүй, жил бүрийн усны дүгнэлт гаргуулсан байгууллагуудыг судалгаанд хамруулдаггүй, сумдын татвар, байгаль орчны байцаагч нараас судалгаа авдаггүй, ус ашиглагч нэмэгдсэн, хасагдсан мэдээлэл байхгүй, ус ашиглагч нартай гэрээ хийдэггүй, хяналт шалгалт хангалтгүйгээс усны төлбөрийн ногдуулалт, төлөвлөлтийг бүрэн хийж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

АТБӨЯХАТ-ын ногдуулалтыг бодитойгоор төлөвлөхийн тулд тээврийн хэрэгсэлийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн болон шинээр нэмэгдсэн тухай судалгааг тухай бүр авч татварын бааз суурийг өргөжүүлэх ажил хангалттай хийгдээгүй байна.

Газрын төлбөрийг газар ашиглагч, эзэмшигчдийг бүрэн хамруулах талаар хангалтгүй ажиллаж байна. Мөн түүнчлэн сум орон нутгийн удирдлага болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнууд идэвхи санаачлага гарган ажиллахад орлого төвлөрүүлэх боломжууд байна. Тухайлбал:

- Газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай Аймгийн ИТХ-ийн 2014.06.30 ны өдрийн 04 тоот тогтоолын дагуу Мал бүхий иргэний малыг хонин толгойд шилжүүлэн 231 төгрөгөөр тооцож бэлчээрийн төлбөрийг Бүрэн, Өндөрширээт, Лүн, Дэлгэрхаан сумд авч хэвшсэн байна. Бусад сумдууд дээрх шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

- Аймгийн хэмжээнд 2003-2014 онуудад 388.3 мянган га газрыг 19.6 мянган иргэн аж ахуйн нэгж эзэмшсэн байна. Газар эзэмшүүлэх ашиглуулах ажиллагааг Газрын тухай хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2012 оны 77 тоот тогтоол, тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой аймгийн Засаг даргын “Хуулийн хэрэгжилт эрчимжүүлэх тухай” 2013 оны 08-р сарын 20-ны өдрийн а/448 тоот, 2013 оны 10-р сарын 15-ны өдрийн а/582 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжууд гарч хууль зөрчин олгосон газрын дуудлага худалдааны анхны үнийг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Эдгээр шийдвэрийн дагуу тооцож үзэхэд одоогийн байдлаар 8388.9 сая төгрөг төвлөрөх боломжтой байна
- Заамар суманд 36 ашиглалтын лиценз бүхий газарт Засаг даргын захирамж гараагүйгээс аймгийн төсөвт төвлөрүүлэх 179.3 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжгүй болж байна.
- Сумдад худалдан борлуулах малын гарал үүслийн гэрчилгээг сумын мал эмнэлэг үржлийн тасаг гарган өгч орлого олох боломж байна. Аймгийн Статистикийн хэлтсийн гаргасан судалгаагаар 2015 онд малчин өрх 553.0 мянган толгой мал зах зээлд худалдан борлуулсан байна. Эдгээрээс 1000 төгрөгийн хураамж авахад 55.3 сая төгрөг орох нөөц боломж байгааг орон нутагт тооцон төлөвлөхгүй байна.
- Хог хаягдлын хураамжийн орлогыг сумдад зөвхөн төсвийн байгууллагын ажиллагсдад болон аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудаас хураан авч, сумын нийт иргэдийг бүрэн хамруулахгүй байна.

Сумдад ажиллах явцад татварын бааз суурийг өргөжүүлэх, татвар төлөгчдийг бүрэн хамруулах, татварын орлогыг төвлөрүүлэх талаар зарим сумдын татварын байцаагч, газрын даамал нар нь идэвхи санаачлагатай ажиллаж байна. Тухайлбал:

- Эрдэнэ сумын газрын даамал нь 5511 өмчилсөн газрын ногдуулалтыг маягтын дагуу хийж, 1167.7 мянган төгрөгийн татварыг ногдуулсан нь бусад сумдаас илүү санаачлагатай ажилласан байна.
- Дэлгэрхаан, Лүн сумын татварын улсын байцаагч нь татварын орлого төвлөрүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж байна. Дэлгэрхаан сум нь хог хаягдлын хураамжийг сумын ИТХ-ийн шийдвэрийн дагуу малчин өрх бүрээс жилд 5000 төгрөг авч хэвшсэн байна.

1.2 Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын ногдуулалт хууль тогтоомжийн дагуу бүрэн хийгдэхгүй байна.

Төв аймгийн ИТХ-ийн 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор татварын 7 нэр төрлийн орлого, татварын бус 3 нэр төрлийн орлого аймгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Татварын орлогын нэр төрлөөр ногдуулалтыг авч үзвэл:

1. Газрын төлбөр

2016 онд аймгийн 27 сумдад нийт 1082.5 сая төгрөгийн газрын төлбөр авахаар ногдуулалт хийгдсэн. Аудитын явцад сумдын газрын даамлуудаас гаргасан судалгааг /хавсралт 13 маягтаар/ дахин нягтлаж, газар эзэмшүүлэхээр

олгосон сумдын Засаг даргын захирамжтай тулган шалгахад зарим сумдад газрын төлбөрийн ногдуулалт дутуу байна.

- Баянжаргалан сум нь аймгийн ГХБХБГазарт 2016 онд газар эзэмшигч, ашиглагчдаас 11.6 сая төгрөгийн газрын төлбөр авахаар ногдуулалт хийсэн ба дахин тооцоход 32.5 сая төгрөг төвлөрүүлэх боломжтой байна. Энэ нь сумын Засаг даргын захирамжаар 2015 онд газар эзэмшүүлэхээр эрх олгосон Нүүдэлчин агро ХХК 0.2 сая төгрөг, Цэцэнс майнинг энд Энержи ХХК-иас 0.9 сая төгрөг, Бөөрөлжүүтийн тал ХХК 1.8 сая төгрөг нийт 2.9 сая төгрөгийг газрын төлбөрт төлөхөөр 2016 онд гэрээ байгуулсныг болон өвөлжөө, хаваржааны газруудад ногдуулалтыг бүрэн тооцоогүй байлаа.
- Эрдэнэ сум нь аймгийн ГХБХБГазарт 2016 онд газар эзэмшигч, ашиглагчдаас 121.0 сая төгрөгийн газрын төлбөр авахаар ногдуулалт хийж хүргүүлсэн байсан ба суманд ажиллах явцад газар эзэмшигчдийн судалгаагаар дахин ногдуулалт хийж үзэхэд 217.8 сая төгрөгийн ногдуулалт гарч байна.
- Зуунмод суманд 2 газрын даамал ажиллаж байгаа боловч 2016 оны газрын төлбөрийг ногдуулалтыг огт хийгээгүй байна.

2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй хөрөнгийн 5.0 сая төгрөгөөс дээш татвар ногдуулсан ААН болон иргэний судалгааг түүвэрлэн шалгахад давхардсан тоогоор 17 иргэн ААН-ийн 45801.8 сая төгрөгийн үнэлгээ бүхий үл хөдлөх хөрөнгөнд татвар ногдуулаагүй гэсэн судалгаа гарч байна. Мөнгөн дүнгээр тооцож үзвэл 274.8 сая төгрөгийн татварыг ногдуулаагүй байна.

Хүснэгтээр харуулбал:

Сумын нэр	Байгууллагын нэр	хэмжээ	Зориулалт	Хөрөнгийн үнэлгээ сая төгрөг	Ногдох татвар сая төгрөг
Алтанбулаг	тэгштплант	600тн, 100м, 18мкв, 83.7, 1260квт	Үйлдвэрлэлийн	3000.0	18.0
Баян	говьхурах	3060	Үнээний фермийн	900.0	5.4
Баян	говьхурах	2970	Үнээний фермийн	900.0	5.4
Баянцогт	монголиан резортс тур транспортейшн	1081	Жуулчны бааз	1758.4	10.6
Борнуур	борнуур	60ш тракторын граж 37 нэр төрлийн барилга	аялал жуулчлал, үйлчилгээний	923.8	5.5
Жаргалант	хөхбаян булаг	1080 5000 1200	Үйлчилгээ, үйлдвэрлэлийн	7079.4	42.5
Заамар	бумбат	23915,4	Үйлдвэрлэлийн	2993.8	18.0
Сэргэлэн	жуулчинмонгол наадам	0	Аялал жуулчлалын	955.5	5.7
Сэргэлэн	монголын алт мак	12200үйлдвэр,1251оф фис,зуухны648	Үйлдвэрлэлийн	11068.0	66.4
Цээл	нэйшнлхимикал	60 хувийн гүйцэтгэлтэй	Үйлдвэрлэлийн	2600.0	15.6
Эрдэнэ	мөнххан оргил ххк	12000	Зочид буудлын	1000.0	6.0
Эрдэнэ	онон	1409,5	Рашаан сувилал, зочид буудал	992.5	6.0
Архуст	аргабарил	11 объект	Үйлдвэрлэлийн	852.6	5.1
Архуст	хишигтэннүүдэлчин	2728	Үнээний фермийн	1780.8	10.7
Архуст	хишигтэн нүүдэлчин	3456	агуулах	2000.0	12.0
Зуунмод	бүти	10827,72	Орон сууц, үйлчилгээний	5232.9	31.4
Зуунмод	бүти	2774	Үйлдвэрлэлийн	1764.0	10.6
	Нийт дүн			45801.8	274.8

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7.2-т “газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг аймгийн төвд 97 хувиар, сумын төвд 98 хувиар хөнгөлнө” гэж заасны дагуу УБХ-ээс ирүүлсэн судалгаанаас давхардсан тоогоор 34152 иргэний газар өмчилсэн бүртгэлийн дагуу татварын ногдуулалтыг хийгээгүй байна.


3.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

АТБӨЯХАТТХуульд үндэслэн аймгийн ИТХурлын 2011 оны 05 дүгээр тогтоолоор тээврийн хэрэгсэлийн төрөл болон хөдөлгүүрийн багтаамжаар тооцож татварын хэмжээг баталсан. АТБӨЯХАТатварыг ногдуулахдаа дээрх тарифийн дагуу татварыг тооцож орлогын дансанд төвлөрүүлдэг боловч сум, тээврийн хэрэгсэлийн тоогоор урьдчилан ногдуулалт хийдэггүй байна.

Автотээврийн үндэсний төвийн Төв аймаг дахь салбараас ирүүлсэн судалгаагаар 2016 онд аймгийн харьяалал бүхий 18855 тээврийн хэрэгсэл бүртгэгдэж 11665 тээврийн хэрэгсэл үзлэг тооллогод хамрагдсан байна. Гэтэл уг татварын орлогыг тооцохдоо 8589 тээврийн хэрэгсэлээр тооцсон байна.

4.Ус ашигласаны нөөцийн төлбөр

Аудитын явцад БОАЖГазраас ирүүлсэн ус, рашаан ашиглагчдын судалгаа, сүүлийн 3 жилд гарсан усны дүгнэлт, Төв аймагт байрлах аялал жуулчлалын бааз, рашаан сувилал, тур операторуудын судалгаа мэдээлэл, татвар төлөгч аж ахуйн нэгжүүдтэй хийсэн ус ашиглах гэрээ зэргийг авч үзэхэд ногдуулалтыг бүрэн хийж чадахгүй байна.



Ус, рашаан ашиглагчдын судалгаагаар аймгийн хэмжээнд 23 суманд 425 ус ашиглагч байхад 132 иргэн, аж ахуйн нэгж буюу 31 хувьд нь усны төлбөр ногдуулж, 69 хувьд нь усны төлбөрийг ногдуулаагүй байна. 4 суманд ус ашиглагч огт байхгүй байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хяналт шалгалтаар ус ашиглалт болон усны төлбөртэй холбоотой зөрчилүүд илэрч байсан байна. Тухайлбал:

Алтанбулаг суманд дараах зөрчлүүд илэрчээ.

- 2016 оны 05 сард үйл ажиллагаа явуулж буй 22 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалт хийхэд 5 аж ахуйн нэгжээс бусад байгууллага зөвшөөрөлгүй ус ашиглаж байсан байна.
- 2015 онд аймгийн төсөвт 15.0 сая төгрөг төвлөрүүлэхээс орлогын төлөвлөгөөний 0.17 хувь буюу 25.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.
- 2016 оны 08 сарын мэдээгээр аймгийн төсөвт усны төлбөр огт оруулаагүй байна.
- 2017 онд төсвийн төлөвлөгөө өгөхдөө хууль бус ажиллаж байсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хаагдсан хэмээн 11 аж ахуйн нэгж байгууллагад усны төлбөр ногдуулахаар саналаа ирүүлсэн.

Эндээс үзэхэд усны төлбөрийг бүрэн ногдуулж төлөвлөж чадахгүй байна.

5.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, өмч хувьчлалын орлого

Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 30 тоот тогтоолоор орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, үйлдвэр, цехийг хувьчлах жагсаалтыг баталсан байна. 2010-2014 онд 647.2 сая төгрөгийн хувьчлагдсан хөрөнгийг графикайн дагуу төлөлт хийхээс байгууллага иргэдтэй гэрээ байгуулж ажиллаагүй, хувьчлагдсан хөрөнгийг төвлөрүүлэх талаар тодорхой үр дүнд хүрсэн ажил хийгдээгүй байна. Нийт хувьчлагдсан 18 цехээс 244.0 сая төгрөг, аймгийн ИТХТ-ийн худалдах шийдвэрийн дагуу худалдагдсан хөрөнгийн 403.2 сая төгрөгийг тус тус төвлөрүүлээгүй байна. Гэтэл 2016 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, өмч хувьчлалын орлогыг дутуу төлөлтийн 9.9 хувьд ноогдох 64.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.3 Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын орлогын ногдуулалтанд үндэслэдэггүй өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөж байна.

Төв аймгийн ИТХ-ийн 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор аймгийн 2016 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 10280.9 сая төгрөгөөр баталсан. Энэ тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын бус орлого болох хүү торгуулийн орлого 483.9 сая төгрөгийг татварын орлогоор баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.6-д “Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” гэж заасан заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг ногдуулалтын дагуу төлөвлөсөн эсэхийг орлогын нэр төрлөөр авч үзвэл:

1.Газрын төлбөр

2016 онд газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 27 суманд хийгдсэн ногдуулалтын дагуу 1082.5 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлогоос 400.0 сая төгрөг нийт 1482.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан. 2016 оны газрын дуудлага худалдааны орлого нь сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдаагүй, ямар суманд газар эзэмшлийн, ашиглалтын ямар төрөлд дуудлага худалдаа явагдах нь тодорхойгүйгээр батлагдсан байна.

Аймгийн 27 сумын газар эзэмшигч ашиглагчдын 2016 оны газрын төлбөрийн ногдуулалтыг дахин тооцож үзэхэд 1233.9 сая төгрөг болж байна. Эндээс үзэхэд газрын төлбөрийн төлөвлөлтийг ногдуулалтаас багаар хийжээ. Өмнөх оны жилийн эцсийн байдлаарх газрын төлбөрийн дутуу төлөлт 350.4 сая төгрөгийг барагдуулж ажиллах шаардлагатай байна.

2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Аймгийн төсөвт төвлөрүүлэх үл хөдлөх хөрөнгийн орлогын төлөвлөгөөг 2016 онд 281.9 сая төгрөгөөр төлөвлөсөн нь аймгийн татварын хэлтсээс гаргасан ногдуулалтаас 15.0 хувиар буюу 49.6 сая төгрөгөөр бага төлөвлөсөн байна.

	ҮХЭХАТ ногдуулалт	ҮХЭХАТ төлөвлөгөө	хувь	илүү дутуу
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар нийт дүн	331,547.97	281,960.80	85.0	-49587.2

3.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

АТБӨЯХАТатварын орлогыг төвлөрүүлэх нэмэгдүүлэх талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй, мотоцикл бүхий иргэдэд татварыг огт ногдуулж, төлөвлөөгүй байна. АТБӨЯХАТ-г төлөвлөхдөө мэргэжлийн байгууллага болон сумдаас тээврийн хэрэгслийн тоог авч түүнд тулгуурлан бодитойгоор төлөвлөөгүй урьд онуудын төлөвлөгөө болон гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж байна. 2016 онд АТБӨЯХАТ-г аймгийн хэмжээнд өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 270.0 сая төгрөгөөр баталсан ба 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 321.3 сая төгрөг төсөвт төвлөрүүлж 119 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр

Усны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө:

- Монгол улсын Засгийн газрын 2011 оны “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 302 дугаар тогтоол,
- Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар тогтоол,
- Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр батлах тухай” 327 дугаар тогтоол,
- Байгаль орчны сайдын 1995 оны “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм батлах тухай” 153 дугаар тогтоол зэрэг эрх зүйн актуудад үндэслэн аргачлалын дагуу тооцдог байна.



Аймгийн хэмжээний ус ашиглагчдын судалгаагаар нийт 425 аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэйгээс 2016 онд нийт 132 иргэн, аж ахуйн нэгжид усны төлбөр ногдуулж аймгийн төсөвт 1389.3 сая төгрөг, орон нутгийн төсөвт 17.8 сая төгрөг нийт 1407.1 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан.

Сум орон нутагт ажиллах явцад усны төлбөрийн ногдуулалт төлөвлөлтийг харьцуулж үзэхэд ногдуулалтаас багаар төлөвлөж байна. Жишээлэхэд Эрдэнэ суманд:

- Ус ашиглагчдийн судалгаагаар 40 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс сумын татварын байцаагч үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийг 17 аж ахуйн нэгжид 43.4 сая төгрөгөөр ногдуулалт хийснийг, аймгийн орлогын мэргэжилтэн 14 аж ахуйн нэгжээр 34.2 сая төгрөг буюу 9.2 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн
- Рашааны төлбөрийг 5 аж ахуйн нэгжид 23.7 сая төгрөг ногдуулсныг 4 аж ахуйн нэгжид 22.5 сая төгрөг буюу 1.1 сая төгрөгөөр дутуу төлөвлөжээ.

Нийт сумдууд аль болох аж ахуйн нэгжийн тоогоо бууруулж ажиллахгүй болсон, хаагдсан гэх шалтгаанаар төлөвлөгөөгөө бага батлуулах чиг хандлагатай болсон, сумдын татварын байцаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар албан үүргээ хангалттай гүйцэтгэдгүй, суурь судалгааг бодитой хийх талаар санаачлагатай ажиллахгүй байна.

5. Улсын тэмдэгтийн хураамж

2016 оны тэмдэгтийн хураамжийн орлогын нэг төрөл болох согтууруулах ундаа худалдах, үйлчлэх зөвшөөрлийн орлогыг төлөвлөхдөө аймгийн төв болон бусад сумдын зөвшөөрлийн тоогоор тооцож төлөвлөлгүй нийт дүнгээр нь 44.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Аймгийн ИТХ-ын 2011 оны 09 дүгээр сарын 22-ний 13 дугаар хуралдааны “Тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 03 тоот тогтоолын 1 дүгээр зүйлийн холбогдох заалтын дагуу 2016 онд аймгийн төвийн 45, сумдын 358 иргэн, аж ахуйн нэгжид спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл сунгахад 44.8 сая төгрөгийн, аймгийн төвд 10, сумдад 91 иргэн, аж ахуйн нэгжийн спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл сунгахад 22.0 сая төгрөгийн, нийт 67.0 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт оруулахаар байна.

6.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, өмч хувьчлалын орлого:

2016 оны эхэнд орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, өмч хувьчлалын орлого нийт 647.2 сая төгрөгийн дутуу төлөлттэй байсан ба үүний 9.9 хувьд ноогдох 64.4 сая төгрөгөөр орлогыг төлөвлөж дутуу төлөлтийг шахаж оруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байна. 2016 онд аймгийн ИТХТ-ийн 2016 оны 3 удаагийн шийдвэрээр нийт 499.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гаргасан байна.

Асуудал 2

Татварын орлогын оны эхний дутуу төлөлт 49.8 хувийн барагдалттай байгаа нь үндсэн чиглэл болон татварын албаны дутуу төлөлтийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй

2.1 Аймгийн төсөвт төвлөрүүлэх төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө 2016 оны эхний 10 сарын байдлаар нийт дүнгээр 106.8 хувиар буюу 550.6 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх төсвийн орлого 2016 оны эхний 10 сарын байдлаар батлагдсан төлөвлөгөөгөөр 8047.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 8597.8 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 106.8 хувиар буюу 550.6 сая төгрөгөөр давж биелэсэн байна. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого нийт дүнгээр биелэсэн боловч Аргалант, Баян, Баянжаргалан, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант зэрэг сумдад 0.3-36.1 хувиар тасарч байна

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзэхэд:

- 5 нэр төрлийн татварын орлогоос 3 нэр төрлийн орлого 19.2-52.2 хувиар давж биелэсэн, 2 нэр төрөл буюу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар 1.8 хувиар, газрын төлбөр 5.6 хувиар тасарсан байна.
- 7 нэр төрлийн татварын бус орлогоос 5 нэр төрлийн орлого 9.8-182.8 хувиар давж биелэсэн, 2 нэр төрлийн буюу түрээсийн орлого 60 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр, тэмдэгтийн хураамж 0.7 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тасарсан байна. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

№	Татварын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Аймгийн нийт дүн	8047.2	8597.8	550.6	106.8
1	Цалингийн ашиг /Суутган-1/	5478.6	5377.3	-101.4	98.2
2	ҮХЭХ-ийн албан татвар	228.8	295.5	66.7	129.2
3	АТБӨЯХ-ийн албан татвар	269.6	321.3	51.7	119.2
4	Газрын төлбөр	1218.7	1150.5	-68.2	94.4
5	Ус ашигласны төлбөр	876.4	1333.9	457.5	152.2
	Татварын орлогын дүн	8072.1	8478.5	406.4	105.0
1	ТГӨО	74.6	81.9	7.3	109.8
2	Түрээсийн орлого	12.0	4.8	-7.2	40.0
3	Хүү торгууль	384.0	444.1	60.1	115.7
4	Нэр зааж ангил-гүй	66.8	85.9	19.0	128.5
5	Орон нутгийн өмч хөрөнгө борлуулсаны орлого	32.0	37.6	5.6	117.6
6	Өмч хувьчлалын орлого	8.0	22.6	14.6	282.8
7	Улсын тэмдэгтийн хураамж	147.8	146.7	-1.1	99.3
	Татварын бус орлогын дүн	725.1	823.6	98.5	113.6
1	ХХОАТ-ын буцаан олголт	-750.0	-704.3	45.7	93.9

1.Газрын төлбөр

Газрын төлбөрийн орлогод 2016 оны эхний 10 сарын байдлаар 1218.7 сая төгрөг төвлөрөхөөс гүйцэтгэлээр газрын төлбөрөөс 811.3 сая төгрөг, оны эхний газрын дутуу төлөлтөөс 115.8 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлогоос 222.8 сая төгрөг нийт 1150.5 сая төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 94.4 хувиар буюу 68.2 сая төгрөгөөр тасалсан байна. 2016 онд газрын төлбөрийн ногдуулалтаар төвлөрөх 1233.9 сая төгрөгийн орлогын 65.7 хувь буюу 811.3 сая төгрөг төвлөрсөн байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад Баяндэлгэр сум нь 2015 оны газрын дуудлага худалдааны орлогоос аймгийн төсөвт төвлөрүүлэх 4.0 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, Аргалант сум 2016 онд газрын дуудлага худалдааны үнийн 50 хувь 14.0 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээс 6.0 сая төгрөгийг дутуу шилжүүлсэнд тус тус төлбөрийн акт бичиж аудитын явцад барагдууллаа.

Газрын дуудлага худалдааны орлогоор 400.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан ба 10 сарын мэдээгээр 16 суманд дуудлага худалдаа явагдаж 222.8 сая төгрөг төвлөрсөн. Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 234-р тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-аар анхны үнэ өссөн нь орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлж байна.

2.Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр

Усны орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 3 жилээр дараах байдлаар төлөвлөж, биелүүлсэн байна.Үүнд:

- 2014 онд 23 сумын 113 ААНэгж төсөвт байгууллага, иргэдээс аймагт нийт 1352.1 сая төгрөг оруулахаар төлөвлөгдсөнөөс 1978.7 сая төгрөг оруулж 626.6 сая төгрөг буюу 146.3 хувиар давуулан биелүүлсэн.
- 2015 онд 22 сумын 127 ААНэгж, төсөвт байгууллага иргэдээс аймагт нийт 1557.1 сая төгрөг оруулахаар төлөвлөгдсөнөөс 1682.5 сая төгрөг оруулж 124.4 сая төгрөг буюу 108.0 хувиар давуулан биелүүлсэн.
- 2016 онд Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийг аймгийн хэмжээгээр 19 суманд 132 аж ахуйн нэгж, иргэн, байгууллагаар тооцон 1333.9 сая төгрөг төлөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1846.8 сая төгрөг тооцож 512.9 сая төгрөг буюу 138.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Жил бүр усны төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж байгаа нь ногдуулалт, төлөвлөлтийг бодитой хийхгүй байгаагаас шалтгаалж байна.

2.2 Татварын орлогын оны эхний дутуу төлөлт 49.8 хувийн барагдалттай байгаа нь үндсэн чиглэл болон татварын албаны дутуу төлөлтийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2016 оны эхний 10 сарын байдлаарх өр барагдалтын мэдээгээр аймгийн төсөвт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогын дутуу төлөлтийн барагдуулалтыг авч үзэхэд 2016 оны эхэнд 1760.0 сая төгрөгийн дутуу төлөлт байснаас 883.8 сая төгрөгийн өр барагдаж, 876.2 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй 49.8 хувийн барагдалттай байна. Татварын алба нь татварын орлогыг бүрдүүлэх талаар хангалтгүй ажиллаж байгаагаас татварын дутуу төлөлт буурахгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын дутуу төлөлт 10 сарын байдлаар /сая төг/

№	Татварын төрөл	оны эхний дутуу	барагдалт	2016.10.30 үлдэгдэл	барагдалтын хувь
1	Цалингийн ашиг /Суутган-1/	788.5	428.5	360.0	45.7
2	ҮХЭХ-ийн албан татвар	83.9	25.6	58.3	69.5
3	АТБӨЯХ-ийн албан татвар	10.4	7.1	3.3	31.7
4	Газрын төлбөр	415.4	151.4	264.0	63.6
5	Ус ашигласны төлбөр	461.8	271.2	190.6	41.3
	Татварын орлогын дүн	1760.0	883.8	876.2	49.8

Асуудал 3

Аймаг, сумдын санхүүгийн тайланд тусгагдсан татварын орлого нь татварын хэлтсийн орлогын мэдээнээс зөрүүтэй байх зөрчил байсаар байна.

3.1 Аймаг, сумдын санхүүгийн тайланд тусгагдсан татварын орлого нь татварын хэлтсийн орлогын мэдээнээс зөрүүтэй байх зөрчил байсаар байна.

СТСХэлтэс болон сумдын санхүүгийн алба нь орон нутгийн орлогын дансыг боловсруулж, татварын орлогын мэдээг хянадаггүй, зөвхөн татварын байцаагчийн дүн мэдээнд тулгуурлан орлого эх үүсвэрийг санхүүгийн тайланд тусгаж байгаагаас татварын орлого зөрүүтэй тайлагнагдах зөрчил байсаар байна. Тухайлбал:

- Аргалант сум нь сумын төсөвт төвлөрүүлэх бугын ясан эврийн төлбөр 5.0 сая төгрөг, Байгалийн баялаг ашигласны төлбөр 3.7 сая төгрөг, түрээсийн төлбөр 4.2 сая төгрөг, газрын дуудлага худалдааны үнийн 50 хувь 14.0 сая төгрөг нийт 26.9 сая төгрөгийг сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, сумын ЗД-ын шийдвэрээр зарцуулсан. Дээрх 26.9 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоор мэдээлээгүй.
- Өндөрширээт сум нь орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн газрын дуудлага худалдааны 50 хувийн 43.0 сая төгрөгийг төсөвт газрын өөрийн орлогоор мэдээлж бүртгэсэн байхад аймгийн татварын хэлтсийн мэдээнд нэр зааж ангиллагдаагүй орлогоор мэдээлсэн.
- Аймгийн ОНХСангийн дансанд газрын дуудлага худалдааны анхны үнэ 94.0 сая төгрөгийг төвлөрүүлж, газрын төлбөрийн орлогоор мэдээлээгүй зэрэг нийт 163.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнийг залруулахаар албан шаардлага бичигдсэн.

Аймгийн ИТХурлын 2013 оны 6 дугаар хуралдааны 01 тоот, 2014 оны 7 дугаар хуралдааны 01 тоот, 2015 оны 10 дугаар хуралдааны 01 тоот тогтоолуудаар газрын дуудлага худалдааны анхны /доод/ үнэ болон тухайн жилд зохион байгуулсан дуудлага худалдааны мөнгийг аймаг, сумдын төсвийн орлогоор дамжуулан ОНСанд хувиарлаж байхаар шийдвэрлэсэн. Гэтэл аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсийн дарга 2015 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 05/774 тоот албан бичиг сумдад хүргүүлж газрын дуудлага худалдааны анхны үнийг аймгийн ОНХСангийн дансанд 100 хувь төвлөрүүлсний дараа суманд 50 хувийг буцаан олгох, тухайн жилд зохион байгуулсан дуудлага худалдааны үнийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 50 хувийг аймгийн газрын төлбөрийн дансанд тус тус оруулахыг мэдэгдсэн байна.

Ингэснээр тухайн төрлийн орлогууд төсвийн орлогын дансаар төвлөрөхгүй байдал үүсч улмаар орлого үнэн зөв мэдээлэгдэж тайланагдахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Татварын хэлтсийн өр барагдалтын мэдээгээр 2015 оны жилийн эцэст аймаг, сумын орон нутгийн төсөвт төвлөрөх 2685.4 сая төгрөгийн дутуу төлөлт байсан ба 2016 оны эхний 10 сарын байдлаар 1639.4 сая төгрөгний дутуу төлөлтийн үлдэгдэлтэй, 38.9 хувийн барагдалттай байна.

Оны эхний татварын дутуу төлөлт /мянган төгрөг/				
	Татварын төрөл		Тайлангаар	Хяналт шалгалтаар
Орон нутагт төвлөрдөг татварын өр	Мал	Тайлан	4,268.60	4,268.60
	Хүү торгууль алданги	ХШ		727,207.80
	Патент, Жишиг	Тайлан	168.90	168.90
	Буу	Тайлан	369.00	369.00
	ИОТТХ	Тайлан	4,226.80	33,736.20
	Суутган-4	Тайлан	22.40	22.40
	Ус	Тайлан	299.30	299.30
	Нөөц	Тайлан		-
	Түгээмэл тархацтай	Тайлан	87,554.20	87,554.20
	Тэм/хураамж	Тайлан	120.00	120.00
	Ой	Тайлан	612.50	594.20
	Суутган-2	Тайлан	49,008.90	1,459.70
Орон нутгийн нийт			146,650.60	762,997.90
Аймгийн төсвийн татварын өр	АТБӨЯХ	Тайлан	10,351.30	309.80
	Газрын төлбөр	Тайлан	415,448.40	415,448.40
	Цалин	Тайлан	788,541.50	11,477.80
	Үл хөдлөх хөрөнгө	Тайлан	83,909.80	4,915.10
	Усны төлбөр	Тайлан	461,801.20	461,801.20
Аймгийн нийт		Тайлан	1,760,052.20	16,702.70
Нийт дүн		Нийт	1,906,702.80	779,700.60

Газрын төлбөрийн дутуу төлөлтийн тайлан, мэдээ, судалгааг харьцуулан үзэхэд ГХБХБГазар, Татварын хэлтэс, сумын газрын даамлын гаргасан тооцоолол өөр өөр байна.

Дутуу төлөлтийн судалгаа /мянган төгрөг/			
	2016 оны эхний газрын дутуу төлөлт		
	ГХБХБГазрын дутуу төлөлтийн мэдээгээр	Сумдын газрын даамлын тооцоолол /маягт 13-аар/	Татварын хэлтсийн ирүүлсэн судалгаа
Газрын дутуу төлөлт	350,431.6	310,321.7	438,649.9

Сумдад ажиллах явцад газрын төлбөрийн дутуу төлөлтийн зөрүүтэй байдлыг тулган шалгахад:

- Эрдэнэ сумын газрын дутуу төлөлт 2015 оны жилийн эцэст ГХБХБГазрын ирүүлсэн тайлангаар 20.5 сая төгрөг, аймгийн Татварын хэлтсийн буюу татварын байцаагчаас авсан судалгаагаар 34.1 сая төгрөг байна. Сумын газрын даамал нь 2015 оны жилийн эцсийн байдлаар газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийг иргэн, аж ахуйн нэгж бүрээр тооцсноор 55.7 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна

- Зуунмод сум нь татварын ногдуулалтыг хийж, татвар төвлөрүүлэх талаар санаачлагагүй ажиллаж 5.4 сая төгрөгийн дутуу төлөлттэй байгаа нь жилд төвлөрүүлэх орлогын 32.3 хувийг эзэлж байна.

Төв аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг сумдын татварын байцаагч, газрын даамал нар нь гараар боловсруулж мэдээлж байна. Газрын төлбөр нь аймгийн хэмжээнд нэг дансанд төвлөрдөгөөс дээрх албан тушаалтнууд нийт 27 сумын орлого төвлөрч буй дансны хуулганаас өөрийн сумын орлогыг тооцоход хүндрэлтэй байдаг байна.

3.2 Татварын ногдуулалтанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тайлангаар 90 аж ахуйн нэгж хяналт шалгалтанд хамруулж 3196.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Татварын ерөнхий хуулийн 29.1-д Татварын улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:, 29.1.8-д татвар ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх, татвар хураахдаа Монгол Улсын татварын болон бусад хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.1.5-д улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ гэсний дагуу улс, орон нутгийн татварын орлогыг мэдээлсэн байна. Гэхдээ дээрх маягт нь татварын орлого, өмчийн татвар, додоодын бараа үйлчилгээний албан татвар, бусад татвар, татварын бус орлого гэсэн ерөнхий дүнгээр мэдээллэгдэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. СТСХэлтэс нь татварын бааз суурийг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ авч, татварын орлогын суурь судалгаа, мэдээлэл бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.
2. Төсвийн орлого бүрдүүлэлтэнд шууд болон шууд бусаар оролцдог байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогын түвшинд нэгтгэж зангидах ажил хийгдэхгүй байна.
3. Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын ногдуулалт хууль тогтоомжийн дагуу бүрэн хийгдэхгүй байна. Ногдуулалтыг бодитой хийхгүй байгаагаас төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэл хангалттай байж чадахгүй байна.
4. Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын орлогын ногдуулалтанд үндэслэдэггүй өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөж байна
5. Татварын орлогын оны эхний дутуу төлөлт 49.8 хувийн барагдалттай байгаа нь үндсэн чиглэл болон татварын албаны дутуу төлөлтийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.
6. Газрын дуудлага худалдааны анхны үнэ /ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 77 дугаар тогтоолоор тооцсон/, тухайн жил зохион байгуулсан дуудлага худалдааны үнийг төсвийн орлогын дансаар дамжуулалгүй аймгийн ОНХСан, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж байгаагаас төсвийн орлого бүрэн төвлөрөхгүй улмаар орлогыг дутуу мэдээлж тайлагнах нөхцөлийг бүрдүүлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.БАТЖАРГАЛД
ЗӨВЛӨХ НЬ:

1. Татварын орлогын суурь судалгааг холбогдох байгууллагуудаар гаргуулж, бодитой мэдээллийн бааз бий болгох
2. Төсвийн орлого бүрдүүлэлтэнд шууд болон шууд бусаар оролцдог байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах
3. Татварын суурь судалгаандаа үндэслэн татварын орлогыг хууль тогтоомжийн дагуу ногдуулалтыг бүрэн хийж төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах
4. Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын оны эхний дутуу төлөлтийг бүрэн барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх
5. Газрын дуудлага худалдааны анхны үнэ /ИТХ-ын 2012 оны 77 дугаар тогтоолоор тооцсон/, дуудлага худалдааны мөнгийг сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс болон ОНХСанд төвлөрүүлсэн зөрчлийг арилгаж, аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлэн хуваарилах

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ
Ц.БАЗАРСАД
Ц.САРАНЧИМЭГ


**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**
41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70272237

2016.12.21 № 05/1632
танай _____ -ны № _____ -т

┌ **ҮАГ-ЫН ХАРЬАА ТӨВ
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ** ┐

“Аймгийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэл, биелэлтийн байдал” сэдэвт гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй танилцав.

Аудитаар гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.


САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ

02 1448
My doc: -/2016 on/ A5 toot